

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



20 25 оны 10 сарын 10 өдөр

№ SR-2025-10

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Ногдол ашгийн бодлогод
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулагдсан эчнээ санал хураалтаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хороо ("СЗХ") нь Банкны үйл ажиллагаанд хийсэн газар дээрх шалгалтаар СЗХ-ны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 тоот "Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай" тогтоолын зарим заалтуудыг Ногдол ашгийн бодлогодоо тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулахыг Банкинд үүрэг болгосныг;
2. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ") СЗХ-ноос үүрэг болгосны дагуу болон Банкны Дүрэмд Ногдол ашгийн бодлогыг нийцүүлэх зорилгоор 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн R-2025-31 тоот тогтоолоороо Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулахыг санал болгосныг; мөн
3. Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-өөс санал болгосны дагуу Ногдол ашгийн бодлогод нэмэлт, өөрчлөлт оруулахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Ногдол ашгийн бодлогод оруулах нэмэлт, өөрчлөлтийг энэхүү тогтоолын хавсралт ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА



ХАВСРАЛТ: ХАСБАНКНЫ НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

1.1 3.2 дахь хэсгийн “Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ” гэсний дараа “Ногдол ашиг зарлан хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.” гэж доорх байдлаар нэмсүгэй:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ.	3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Хагас жилийн ногдол ашиг хуваарилах эсэхийг оны эхний хагас жил дууссанаас хойш 120 хоногийн дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэнэ. <u>Ногдол ашиг зарлан хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.</u>

1.2 4.1 дэх хэсгийн “эрх бүхий этгээд хэлэлцэн” гэсний дараа “шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн” гэж доорх байдлаар нэмсүгэй:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн шийдвэрлэнэ.	4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд хэлэлцэн <u>шийдвэрлэж, хувьцаа эзэмшигчид эцэслэн</u> шийдвэрлэнэ.

1.3. Дараах 3.3, 5.8, 5.9 дэх хэсэг, 5.3.4 болон 5.4.5 дахь заалтыг доорх байдлаар өөрчлөн найруулсугай:

Одоогийн заалт	Нэмэлт, өөрчлөлт оруулсан заалт
3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэснээр ногдол ашиг авах эрхтэй.	3.3 <u>Монголбанкнаас зөвшөөрөл олгосон тохиолдолд,</u> Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн өөс <u>шийдвэрлэсэнээр</u> шийдвэрлэж, <u>Хувьцаа эзэмшигчдийн эцэслэн баталснаар</u> ногдол ашиг авах эрхтэй.

5.3.4 Ногдол ашиг тараах хэлбэр (Банк өөрөө эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан);	5.3.4 <u>Эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан</u> Ногдол ашиг тараах хэлбэр арга (Банк өөрөө эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулан);
5.4.5 Банк ногдол ашгийг өөрөө эсхүл мэргэжлийн зуучлагч байгууллагаар дамжуулан тараахын аль нь болох;	5.4.5 Банк ногдол ашгийг өөрөө эсхүл мэргэжлийн <u>Эрх бүхий</u> зуучлагч байгууллагаар дамжуулан <u>ногдол ашиг тараах арга</u> тараахын аль нь болох;
5.8 Банк нь ногдол ашгийг Банкинд данстай хувьцаа эзэмшигчийн цахим болон бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Банкин дахь дансанд шилжүүлэх, харин Банкинд дансгүй хувьцаа эзэмшигчийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хувьцаа эзэмшигчийн нэр дээр бүртгэлтэй банкны дансанд тус тус шилжүүлэх байдлаар төлнө.	5.8 Банк нь ногдол ашгийг Банкинд данстай хувьцаа эзэмшигчийн цахим болон бичгээр гаргасан хүсэлтийн дагуу Банкин дахь дансанд шилжүүлэх, харин Банкинд дансгүй хувьцаа эзэмшигчийн хувьд үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хувьцаа эзэмшигчийн нэр дээр бүртгэлтэй банкны дансанд тус тус шилжүүлэх байдлаар төлнө. <u>Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 28 тоот “Ногдол ашиг тараах ажиллагааг нарийвчлан тогтоох тухай” тогтоолд заасны дагуу Банкны нийт гаргасан хувьцааны тав болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь Банкинд бичгээр хүсэлтээ урьдчилан гаргасан тохиолдолд, ногдол ашгаа арилжааны банкин дахь харилцах эсхүл хадгаламжийн дансаар хүлээн авч болно. Бусад хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд нь шилжүүлнэ.</u>
5.9 Ногдол ашиг төлөх өдөр нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан өдрөөс хойш 15 хоногоос хэтрэхгүй байна.	5.9 Ногдол ашиг төлөх өдөр нь Монголбанкнаас зөвшөөрөл авсан өдрөөс хойш 15 хоногоос хэтрэхгүй байна. <u>Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд, жилийн эцсийн ногдол ашгийг тухайн санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор хувьцаа эзэмшигчдэд тараана.</u>